



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/602

Есөнбулаг

Теле хяналтын төв байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 7.2.2 дахь зорилт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг идэвхжүүлэх, аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн харуул хамгаалалтад хяналт тавих, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор теле хяналтын төв болон хэвлэл мэдээллийн төвийг Архивын барилгын В1 давхрыг түшиглэн байгуулсугай.

2. Хяналтын төвийн дэргэд гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилго бүхий хэвлэл мэдээллийн төвийг ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

3. Хяналтын төвийн тохижилтын ажил болон цаашдын ашиглалт үйл ажиллагааны зардлыг төсөвт суулгаж ажиллахыг Есөнбулаг сум (А.Алтанхуяг)-т даалгасугай.

4. Хяналтын төвийн хэвийн үйл ажиллагааг хангах, байнгын хяналтад оруулж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-т тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР